БАТЛАВ
БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Х.БАТЖАРГАЛ

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ (УЛСЫН ХЭМЖЭЭНД)
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН "БАГШ ШИРЭЭ, САНДАЛ, БИЧИГ ХЭРГИЙН ШҮҮГЭЭ"
ХУДАЛДАН АВАХАД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

УТ2601502049: Багц - 2 **2026.01.30**

Тоног төхөөрөмж		Дараах техникийн үзүүлэлт хангасан (эсхүл түүнтэй дүйцэх)	Тоо, ширхэг
1.Багш ширээ			
Материал:	Төрөл:	* Шилмүүст ба навчит төрлийн зүймэл болон шахмал модон хавтан	700
	Зузааны хэмжээ /мм/	* 20см, (нягт өндөртэй)	
	Өнгө:	* Цайвар шаргал	
	Өнгөлгөө:	* Тунгалаг лакан болон гоёлын ламинар, меламин	
	Хэмжээ:	* Урт: L1400мм, Өргөн: W750мм, Өндөр: H720мм.	
	Хийц:	* Тавцан болон нүүрний хэсгийг тунгалаг лакан болон гоёлын ламинар, меламин, өнгөлгөөгөөр өнгөлсөн шилмүүст ба навчит төрлийн зүймэл модон хавтангаар хийнэ. * Меламин бүрэлттэй, ус чийгт тэсвэртэй тавцан, хөл, урд талын нүүр, шургуулга бүхий шүүгээг 20см-ийн зузаан, нягт өндөртэй, сайн чанарын шахмал модон хавтангаар хийх бөгөөд тавцангийн ирмэгийг зориулалтын эмжээр, ирмэг хуулга болон PVC материалаар өнгөлсөн байна. * Ширээний эд ангиудын хоорондын угсралтыг мебелийн далд холбоосны шурган хэрэгслээр хөдөлгөөнгүй бат бөх байхаар холбоно. * Ширээний доод хэсэгт 400(W)*530(L)*600(H) мм хэмжээтэй баруун болон зүүн талд шилжүүлэн байрлуулах боломжтой жижиг шургуулга бүхий шүүгээ байна. * Шүүгээ нь ширээний эх биед бэхлэгдэж өлгөгдсөн (эсвэл дугуйтай байж болно) байдалтай байх бөгөөд шургуулгууд нь шарикан болон роликон хийц бүхий шулуун механизмаар хөдөлгөөн хийгдэх ба тус бүрдээ бариултай байна. * Ширээний хөлийг 1.2мм зузаантай хүнд даацын төмөр материалаар хийж, шалнаас хөндийрүүлсэн, зориулалтын зөөлөвч тогтоосон байна.	
	Бусад:	* Угсралтын ажлын зураг	
		* Иж бүрдлийн жагсаалт	
		* Зориулалтын сав баглаа боодол	
	Дүн:		**700**
2.Багш сандал			

Материал	Өнгө:	* Хар	505
	Хийц:	* Чанар стандартын шаардлага хангасан төмөр рамтай, түшлэгтэй, түшлэг болон суудал нь зөөлөвчтэй, торон артай тул агаар сайн нэвтрүүлнэ, хөл нь хуванцар хамгаалалттай, гарын түшлэгтэй, полиэфир материалтай нимгэн даавуун бүрээстэй байна. PVC материалтай 5 ширхэг дугуйтай байна. * Даац: 150 кг	
		* Зориулалтын сав баглаа боодолтой байна	
	Дүн:		**505**
3.Багш бичиг хэргийн шүүгээ /модон/			
Материал	Төрөл:	* Модлог хавтан	752
	Зузааны хэмжээ /мм/	* 20см, нягт өндөр	
	Өнгө:	* Цайвар шаргал	
	Өнгөлгөө:	* Тунгалаг лакан болон гоёлын ламинар, меламин	
	Хэмжээ:	* Урт: L800мм, Өргөн: W400мм, Өндөр: H1900мм.	
	Хийц:	* Бичиг хэргийн шүүгээний дээд хэсэг 3 тасалгаа бүхий 2 тавиуртай байх бөгөөд, тавиур хоорондын зай 400мм-ээс багагүй байна. * Нүүрэн хэсэг нь металл рамтай 4мм зузаантай шилэн хийц бүхий 2 хаалгатай байна. * Шүүгээний доод хэсэгт тасалгаат тавцантай нүүрэн талдаа хавтан хийц бүхий 2 хаалгатай ба шилэн болон хавтан хаалгануудыг зориулалтын нугасаар их биед тогтоон угсарсан байна. * Шүүгээний дээд, дунд, хоёр хажуу хана, ёроол, хөл, хавтан хаалгыг олон улсын E0, E1 стандарт хангасан модлог хавтангаар хийх бөгөөд хавтангийн хажуу хөвөөг өнгө дагуу 1.2мм-ээс доошгүй зузаантай PVC материалаар хийнэ. * Бичиг хэргийн шүүгээний эд ангиудын угсралтыг тавилгын зориулалтын, далд холбоосны шурган хэрэгслээр хөдөлгөөнгүй бат бөх байхаар холбоно.	
	Бусад	* Угсралтын ажлын зураг	
		* Иж бүрдлийн жагсаалт	
		* Зориулалтын сав баглаа боодол	
	Дүн:		**752**

.....oOo.....